

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН  
2018-2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2019 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

№	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх арга зам	Төсөв, санхүүжилт	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5
1.	Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	<b>Нэг. Төрийн албыг чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлэх, зарчмыг баримтлан дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ</b>		
		1.Төрийн үйлчилгээний тухайн албан тушаалд тавигдах нөхцөл, болзлыг хангасан иргэн, албан хаагчийг сонгон шалгаруулах замаар шинээр томилох	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажлын байрны сул орон тоог байгууллагын ажлын байрны зарыг <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> цахим хуудас болон зарын нэгдсэн цахим хуудас <a href="http://www.unegui.mn">www.unegui.mn</a> , <a href="http://www.biznetwork.mn">www.biznetwork.mn</a> , байгууллагын мэдээллийн ил тод байдлын самбарт тухай бүр байршуулж нийтэд мэдээллэхийн зэрэгцээ, Хөдөлмөр эрхлэлтийн газар болон дүүргүүдийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст жилийн эцсийн байдлаар 28 удаа хүргүүлэн ажиллаж жилийн эцсийн байдлаар дээрх хөдөлмөр зуучлалын мэдэгдэл, зараар ирсэн нийт 75 иргэний материалаас сонгон шалгаруулт хийж 50 хүн шинээр ажилд орсон байна. Шинээр ажилд орж байгаа ажилтнуудад газрын холбогдох дүрэм, журам, албан тушаалын тодорхойлолтыг танилцуулж, хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байна.	100%
		2. Газрын цахим хуудас <a href="http://khangardi.mn">khangardi.mn</a> сайтад ажлын байрны нээлттэй зар, мэдээ мэдээллийг тухай бүр баяжуулж тавих	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажлын байрны сул орон тоо болон бусад мэдээ, мэдээллийг байгууллагын <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> цахим хуудас болон мэдээллийн самбарт тайлант хугацаанд нийт 106 удаа байршуулж ажилласан.	100%
		3. Тухайн албан тушаалд тавигдах ажлын байрны тодорхойлолтыг оновчтой тодорхойлох	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан төрийн албан хаагчийн хувийн хэргийг шинэчлэх, бүрдэл ажлын хүрээнд нийт 289 ажилтан албан хаагчдын А,Б анкет, хувь хүний намтар шинэчлэн боловсруулсан.	100%
		4. Ажлын байрны тодорхойлолтонд заагдсан чиг үүргийн	Ажлын байрны тодорхойлолтонд заагдсан чиг үүргийн хүрээнд ажил үүргээ гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавин ажиллаж, ажлын үр дүнг сар бүр ур чадвар, улирал тутам үр дүнгийн урамшууллыг олгож ажилласан.	100%

1	2	3	4	5
1.	Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	хүрээнд ажил үүргээ гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавих		
		5. Ажилтан, албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллана.	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын 2019 оны А/73 дугаар тушаалаар захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагчдын 2019 оны жилийн эцсийн ажлын үр дүнг үнэлж дүгнэх ажлын хэсгийг томилсон. Ажлын үр дүнг дүгнүүлэх 45 албан хаагчаас 44 албан хаагчийн ажлыг дүгнэж, 1 албан хаагч чөлөөтэй шалтгаанаар дүгнэгдээгүй. Үр дүнг дүгнүүлсэн албан хаагчаас А үнэлгээтэй 18, В үнэлгээтэй 17, С үнэлгээтэй 4 албан хаагч байлаа.	100%
		6. "Ёс зүйн дүрэм"-ийг мөрдлөгө болгон ажиллана.	Засгийн газрын 2018 оны "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоол, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийслэлийн Засаг даргын 2018 оны "Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай" 03 дугаар албан даалгаврыг ажилтан, албан хаагч бүр мөрдөн ажилласан. Тайлант хугацаанд ёс зүйн зөвлөл 7 удаа хуралдаж тухай бүр Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- 1 албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1.1-ээр,</li> <li>- 1 албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1.2-оор,</li> <li>- 7 албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1.3-д зааснаар сахилгын шийтгэл ногдуулж, 3 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах шаардлагагүй гэж үзсэн.</li> </ul> Мөн ажилтан, албан хаагчдын сахилга бат, ёс зүйн хэм хэмжээг таниулах, ёс зүйн дүрмийг дагаж мөрдүүлэх ажлын хүрээнд мэргэжлийн байгууллага, багш нартай хамтран сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвтэй хамтран "Хувь хүний хөгжил" сэдэвт сургалтад 45;</li> <li>- "Ажлын цаг ашиглалт, ажлын байрны сэтгэл зүй, эмх цэгц" сэдэвт сургалтад 40;</li> </ul>	100%



1	2	3	4	5		
1.	Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх		<ul style="list-style-type: none"> <li>- НЗЗ-ны 1, 2-р байрны үйлчилгээний ажилтнуудад “Байгууллагын соёл, ажилтны харилцаа, хандлага” сэдэвт сургалтад 33;</li> <li>- Нийслэлийн Засаг захиргааны 3, 4 дүгээр байрны үйлчилгээний болон инженер техникийн ажилтнуудад “Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх, үйлчилгээний ажилтны ёс зүйг хангаж ажиллах нь” сургалтад 27 албан хаагч тус тус хамрагдсан.</li> </ul>			
		7. Хэлтэс, албадуудын бүтэц, орон тоо, шилжилт хөдөлгөөн өөрчлөлтийг тухай бүр шинэчлэн батлана.	Хүний нөөцийн систем болон UB ERP-д шинээр ажилд орсон, ажлаас чөлөөгдсөн ажилтан, албан хаагчдын хөдөлгөөний цагийн бүртгэл болон 237 ажилтан, албан хаагчдын ээлжийн амралтын мэдээллийг оруулж ажилласан.	100%		
		<b>Хоёр. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг сайжруулах, тэдгээрийн мэдлэг мэргэшил, ур чадварыг байнга дээшлүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ</b>				
		1. Тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг мэргэшил дээшлүүлэх сургалтанд сурах бололцоогоор хангаж дэмжлэг үзүүлэх.	Тайлант хугацаанд нийт 24 удаа сургалт зохион байгуулснаас хувь хүний харилцаа, ёс зүй, ажлын цаг ашиглалтын чиглэлээр 4, мэргэжлийн зэрэг олгох, ур чадвар нэмэгдүүлэх, ажлын байрны давтан сургалтын чиглэлээр 5, ажлын туршлага солилцуулах 2, ажилтан, албан хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 13 сургалтыг тус тус төлөвлөсөн хуваарийн дагуу хийж, давхардсан тоогоор 500 гаруй ажилтан, албан хаагчид хамрагдсан. 2019 оны жилийн эцсийн байдлаар 3.300.000 төгрөгийг сургалт зохион байгуулахад зарцуулсан байна.	100%		
2. Гадаад дотоодын мэргэшил дээшлүүлэх, гадаад хэлний урт богино хугацааны сургалтанд шаардлага хангасан ажилтан, албан хаагчдыг дэмжиж хамруулах						

1	2	3	4	5
1.	Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	3. Гадаад оронд туршлага судлах, сургалт семинарт хамруулна.	Тайлант хугацаанд БНХАУ-ын Ханжею хотын Жэжан мужийн уламжлалт анагаах ухааны их сургуулийн "Нэг бүс нэг зам" сэдэвт олон улсын 1 сарын сургалтад 1 албан хаагч хамрагдсан.	100%
		4. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны сертификат олгох сургалтанд хамруулах.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад тайлант онд 3 албан хаагч хамрагдаж АЗ серфитикат авсан.	100%
		5. Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, шинэчлэл, стандартын талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах	Мэргэжлийн байгууллагатай хамтран баримт бичиг, шинэчлэл, стандарттай холбоотой сургалтыг зохион байгуулж ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн архивын газартай хамтран 2019 оны 04 сарын 16-ны өдөр "Баримт бичиг боловсруулалт, албан хэрэг хөтлөлтийн стандарт" сэдэвт сургалт зохион байгуулж албан хаагч 37;</li> <li>- Мөн Хэл зүйн ухааны доктор Ж.Ганбаатартай хамтран 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2018 оны 01 дүгээр тогтоолоор баталсан "Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь"-ийг албан хаагчдад таниулах болон зөв бичих дүрэмд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотой мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулж албан хаагч 37 тус тус хамрагдсан.</li> </ul>	100%
		6. "Мэдээллийн цаг"-ийг тодорхой чиглэл зорилго төлөвлөгөөтэй зохион байгуулах	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/13 дугаар тушаалаар батлагдсан мэдээллийн цагийн төлөвлөгөөний дагуу 7 удаагийн мэдээллийн цагийг 11 мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж ажилтан, албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан. Үүнд: БСШУЯ-ны Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр "Дасгал хөдөлгөөн – эрүүл аж төрөхүй" сэдвээр;	100%



1	2	3	4	5
1.	Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх		<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Онцгой байдлын газрын сургалт, суртчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Чинбат 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр “Гамшгаас хамгаалах менежментийн хамгаалах менежментийн тогтолцоо, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээ” сэдвээр;</li> <li>- Төгс Баян Хүрээ” ХХК-ийн захирал Х.Баярмагнай 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдвээр;</li> <li>- Улаанбаатар их сургуулийн Гэр бүл судлалын хүрээлэнгийн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Б.Оюун-Эрдэнэ 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр “Хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн оролцоо” сэдвээр;</li> <li>- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сургалт, олон нийттэй харилцах хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Болормаа “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль түүний үйлчлэл” сэдвээр;</li> <li>- Агаарын бохирдолтой тэмцэх газрын ахлах мэргэжилтэн Г.Даваажаргал сайжруулсан шахмал түлшний хэрэглээ, нийлүүлэлтийн талаар;</li> <li>- Оном сангийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан М.Мэндбаяр “Артерийн даралт ихсэлт, түүний эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх”, “Стресс менежмент” сэдвээр;</li> <li>- Нийслэлийн цагдаагийн удирдах газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран тус хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Э.Баярбаясгалан “Зөрчлийн тухай хууль” сэдвээр;</li> <li>- ДиЖиБи ХХК эм ханган нийлүүлэх төвийн эмч Б.Мөрөн “Томуу, томуу төст, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мөн эмийн зохистой хэрэглээ” сэдвээр;</li> <li>- Нийслэлийн цагдаагийн удирдах газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, ахлах дэслэгч Б.Нямсүрэн “Цахим гэмт хэргээс</li> </ul>	

1	2	3	4	5
1.	Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	7. Гадаадын болон орон нутгийн Засаг захиргааны байгууллагуудын ажлын туршлагатай танилцан, тэдний ажлын амжилтаас нь суралцана.	урьдчилан сэргийлэх” сэдвээр тус тус мэдээлэл өгсөн. Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газраас Нийслэл, 21 аймгийн нийтлэг үйлчилгээний байгууллагуудын удирдах ажилтны сургалт 2019 оны 10 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Тус сургалтад 3 албан хаагч хамрагдаж, орон нутгийн захиргааны байгууллагуудын нийтлэг үйлчилгээний өнөөгийн байдал, захиргааны нийтлэг үйлчилгээний онцлог бүтэц зохион байгуулалт, ажлын дадлага туршлагатай танилцаж, туршлага солилцсон.	100%
		8. Ажилтан, албан хаагч бүрт үндсэн ажлаасаа хөндийрөхгүйгээр өөрийн мэдлэг мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангах	Тайлант хугацаанд захиргааны албан хаагчдаас төрийн захиргааны менежмент 1, бизнесийн удирлага 1, эрх зүй 1 нийт 3 албан хаагч магистр зэргээ хамгаалан төгссөн. Мөн бизнесийн удирдлагын магистрант 1, нягтлан бодох бүртгэл мэргэжлээр 2 албан хаагч тус тус суралцаж байна.	100%
2.	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, тав тухтай орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	1. Албан хаагчдыг шаардлагатай компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ажлын өрөөгөөр хангахаас гадна үйлчилгээний ажилчдад ажлын хувцас, шаардлагатай эд материалаар хангаж ажиллах.	Захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагчдад шаардлагатай 22 төрлийн техник, тоног төхөөрөмж /65.448.880 төгрөг/, үйлчилгээний болон байр ашиглалтын албаны ажилчдад ажлын хувцас /8.776.000 төгрөг/, шаардлагатай ажлын багаж хэрэгслээр /7.036.500 төгрөг/ тус тус ханган ажилласан.	100%
		2. Ажлын бүтээмж, үр дүнг холбогдох журмын хүрээнд улирал бүр үнэлж дүгнэн ур чадварын нэмэгдэл олгоно.	Ажилтан, албан хаагчдын ажлын бүтээмж, үр дүнг холбогдох журмын дагуу улирал бүр дүгнэж, сар бүр ур чадварын нэмэгдэл олгож ажилласан. Давхардсан тоогоор 318 ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдэлд 291,826,791, зэргийн нэмэгдэлд 5,014,165 төгрөгийг зарцуулсан байна.	100%
		3. Биеийн тамирын тэмцээн уралдаан зохион байгуулна	- Газрын даргын 2019 оны А/31 дугаар тушаалын дагуу 2019 оны байгууллагын аварга шалгаруулах спортын наадмыг 2019 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр ширээний теннис, дартс, 05 дугаар сарын 05-ны өдөр гар бөмбөг, сагсан бөмбөг гэсэн 4төрлөөр тус тус зохион байгуулсан.	100%



1	2	3	4	5
2.	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, тав тухтай орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах		<p>Байгууллагын 9 багийн 90 гаруй тамирчид хурд, хүчээ сорьж оролцсон.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Мөн Нийслэлийн 380 жилийн ойн хүрээнд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын дунд гурван төрлөөр "Спортын наадам"-ыг 2019 оны 11 дүгээр сарын 09,10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. Спортын наадамд 11 агентлагын 290 тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцсон.</li> </ul>	
		4. Эрхэлсэн ажилдаа идэвхи зүтгэл гаргаж, үүргээ бүрэн биелүүлж, амжилт гаргасан ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулна.	Тайлант хугацаанд эрхэлсэн ажилдаа идэвх санаачлага гаргаж, амжилт гаргасан ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийг өндрөөр үнэлж төрийн дээд шагналаар 4, Засгийн газрын шагналаар 9, Монголын Залуучуудын Холбооны шагналаар 5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар 16, Нийслэлийн Засаг даргын шагналаар 30, Нийслэлийн 380 жилийн ойн шагналаар 128 ажилтан, албан хаагчдыг тус тус шагнаж урамшуулсан. Нийт давхардсан тоогоор 318 ажилтан, албан хаагчдад 317,952,253 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.	100%
		5. Мэдээллийн дотоод сүлжээний найдвартай ажиллагааг тогтмол хангана	Мэдээллийн дотоод сүлжээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор Нийслэлийн мэдээлэл, технологийн газартай хамтран 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдөр "Мэдээллийн аюулгүй байдал" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар мэдээллийн аюулгүй байдлын үндсэн ойлголт, өдөр тутмын цахим хэрэглээнд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг мэдээлэл өгсөн.	100%
		6. Ээлжийн амралтын хуваарийг батлуулж, олговрыг тухай бүр олгоно.	Газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан ээлжийн амралтын хуваарийг батлуулсан. Хуваарийн дагуу 237 ажилтан, албан хаагч ээлжийн амралтыг биеэр эдлэсэн байна.	100%
			<p>Эрүүл амьдрах хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, ажлын байрны ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит 15-64 насны хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн төвшинг тогтоох сорилыг 2019 оны 04 дүгээр сар, өдөр</li> </ul>	

1	2	3	4	5
2.	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, тав тухтай орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	<p>7. Жил бүр албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр оруулж, шинжилгээ хийлгэн, эмчилгээ хийлгэх боломж олгохын тулд төрийн эмчит эмнэлэг, сувилалын байгууллагуудтай гэрээ хийж хамтран ажиллах.</p> <p>8. Цасны баяр, явган аялалыг жилд 1 удаа зохион байгуулна</p>	<p>зохион байгуулж 202;</p> <ul style="list-style-type: none"> <li>- НИТХ, НЗДТГ, ЧДЭМТ, "Оном" сан хамтран 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдөр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт сурталчилгааны өдөрлөгийг зохион байгуулж 141;</li> <li>- Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, "Монос фарм трейд" ХХК-тай хамтран 2019 оны 05 дугаар сарын 28-30-ны өдөр урьдчилан сэргийлэх үзлэгийг /усны дэлгэрэнгүй шинжилгээ, рентген зураг, хэвлийн эхо, зүрхний цахилгаан бичлэг, цусан дах сахар хэмжих, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг/ зохион байгуулж 250 гаруй ажилтан, албан хаагч тус тус хамрагдсан.</li> </ul>	100%
3.	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	<p>1. Байгууллагаас орон сууц хүссэн албан хаагчдын өргөдөл хүсэлтийг үндэслэн ажилласан хугацаа, ажлын үр дүн, амьдралын нөхцөл байдал зэргийг харгалзан хөнгөлттэй зээл тусламжид хамруулах.</p> <p>2. Албан хаагчдын газар өмчлөлийн судалгааг гаргаж, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.</p> <p>3. Ажилтны гэр бүлийн гишүүн /нөхөр, эхнэр,</p>	<p>Монгол улсын Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоол, НИТХ-ын 2019 оны 115 дугаар тогтоолын дагуу "Буянт-Ухаа 2" хорооллын түрээсийн орон сууцны бүртгэлээр 4 ажилтан хамрагдаж орон сууцанд орсон.</p> <p>Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, тогтвор суурьшлыг хангах, ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд байгууллагын дотоод журамд заасны дагуу 30 ажилтан, албан хаагчдад өргөдлийн дагуу буцалтгүй мөнгөн</p>	100%



1	2	3	4	5
		хүүхэд, эцэг эх/ нас барсан тохиолдолд мөнгөн олговор олгох	тусламжийг үзүүлсэн. Гэр болон галалгаатай байшинд амьдардаг ажилтан, албан хаагчдад түлээ, нүүрс авахад нь хөнгөлөлт, тусламж үзүүлэх 176 ажилтан албан хаагчдад түлшний хөнгөлөлт үзүүлсэн. Мөн ажилчдын унааны зардалд 29.326.500 төгрөг, хоолны зардалд 233.299.400 төгрөгийг тус тус олгосон байна.	
		4. Ажилтны орон байр байгалийн гэнэтийн тохиолдолд даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж мөнгөн тусламж үзүүлж болно.	-	-

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ч.ШИНЭЧИМЭГ

ХЯНАСАН:  
ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН



Т.ИТГЭЛ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ДОТООД АЖИЛ, СУРГАЛТ  
ХАРИУЦСАН АЖИЛТАН



Ц.ҮРЭЛМАА